



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/240

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын Гэр бүлийн өдрийг угтсан “Гэр бүлийн үнэ цэнэ, өнөөгийн байдал” илтгэлийн уралдааны зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан 1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0515

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 18-ны өдрийн  
46 дугаар захирамжийн  
хавсралт

**“ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ”  
ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Шагналын төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Өргөмжлөл	3	50,000	150,000
2.	Мөнгөн шагнал	3	1 дүгээр байр 400,000 2 дугаар байр 300,000 3 дугаар байр 200,000	900,000
3.	Бусад	-	50,000	50,000
Нийт				1,100,000

-oOo-